



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А116

Шивээговь сум

Сумын “Цахилгааны эх үүсвэрт холбогдоогүй иргэдийн өмчилсөн газарт байр зүйн зураг үйлдэх” ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Геодези зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1, 5.8.3, Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Нэмэлт өөрчлөлт оруулах тухай 129 дүгээр тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны “Сумын 2020 оны төсөв батлах тухай” 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Цахилгааны эх үүсвэрт холбогдоогүй иргэдийн өмчилсөн газарт байр зүйн зураг үйлдэх” ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Б.Баасанбат (Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга:	З.Баасандалай (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүн:	Э.Баярмагнай (Сумын Газрын даамал)

2. Байр зүйн зураг үйлдэх ажлыг ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан гүйцэтгэлийг хангуулж, холбогдох акт үйлдэн гүйцэтгэлийг хүлээн авч ажиллахыг ажлын хэсгийн дарга /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212:0033